


Эрчимтэй хөгжиж буй  
**Монгол Улс**  
ЖАЙКА-ийн  
хамтын ажиллагаа



Японы Олон Улсын Хамтын  
Ажиллагааны Байгууллага (ЖАЙКА)  
2023.8

# 1. ЖАЙКА-ийн товч танилцуулга

## " Д а я н д э л х и й г и т г э л ц л э э р х о л б о н о "

ЖАЙКА нь,

Хүн төрөлхтний гэрэлт ирээдүйд итгэн,

Бүхий л боломжийг эрэлхийлэн,

Эрх чөлөөт, амар амгалан эх дэлхийг цэцэглүүлэхийг эрмэлзэж,

Хамтдаа даян дэлхийг итгэлцлээр холбоно.



## Хүн төрөлхтний аюулгүй байдал

Хүний амь нас, аюулгүй байдал баталгаажсан, эрүүл нийгмийг цогцлоохыг зорино.



People

### Хүн бүр эрүүл, тайван орчинд амьдрах нийгмийн төлөө

- Боловсрол
- Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ
- Нийгмийн хамгаалал



Peace

### Айдас, хүчирхийлэлгүй, амар амгалан, шударга нийгмийн төлөө

- Зөрчил, мөргөлдөөнгүй улс орныг бүтээх
- Хууль, эрхзүйн орчныг сайжруулах
- Хүйсийн тэнцвэртэй байдлыг хангах, эмэгтэйүүд, охидыг дэмжих



Prosperity

## Чанартай өсөлт

Байгаль орчинд хор хөнөөлгүй, тэнцвэртэй, тогтвортой өсөлтийг бий болгохыг зорино.

### Байгальтайгаа зохицсон баялаг нийгэм, эдийн засгийн хөгжлийн төлөө

- ХАА, хөдөөгийн хөгжил
- Хувийн хэвшлийн салбарын хөгжил
- Хот, бүс нутгийн хөгжил
- Цэвэр, тогтвортой эрчим хүчний хөгжил
- Тээврийн дэд бүтцийн хөгжил



Planet

### Эх дэлхийн хүрээлэн буй орчныг хамгаалахын төлөө

- Нөөцийн тогтвортой менежмент
- Байгаль орчныг хамгаалах, орчны менежмент
- Усны нөөцийг хамгаалах, хангах
- Гамшгаас урьдчилан сэргийлэх

# Товч танилцуулга



Гадаад дахь  
Төлөөлөгчийн газар

**96**



Япон дахь салбар төвүүд

**15**



Нийт ажилтан

**1968**



Хамтын ажиллагааны  
цар хүрээ

**139**

орон, бүс нутаг

- ※ Гадаад, дотоод дахь салбар 2022.7.1-ны байдлаар
- ※ Ажилтны тоо 2023.1.1-ний байдлаар
- ※ Дэмжлэг үзүүлдэг орон, бүс нутаг 2021 оны байдлаар



## **2. Хамтын ажиллагааны стратеги**

## ① Макро эдийн засгийн эрүүл үйл ажиллагаа ба засаглалыг бэхжүүлэх

- Байгалийн баялгаас хэт хамааралтай байдал, төлөвлөөгүй зарлага зэргээс үүдэн төсвийн алдагдал нэмэгддэг. Төрийн менежментийн суурийг бэхжүүлэхийн тулд эрсдлийг бууруулах макро эдийн засгийн бодлогыг боловсруулан хэрэгжүүлж, орлого, зарлагын менежментийг оновчтой хэрэгжүүлэх нь тулгамдаж буй асуудал юм. Мөн бизнесийг хөгжүүлэх суурь болох санхүүгийн эрүүл тогтолцоог хөгжүүлж, тогтворжуулах шаардлагатай байна.
- Засаглалын хувьд авлига, хээл хахууль тулгамдсан асуудал байдаг. Ил тод байдлыг хангах, төрийн үйлчилгээг сайжруулах зорилгоор цахим засаглалыг (E-Mongolia) нэвтрүүлж байгаа хэдий ч төрийн албан хаагч, иргэд зэрэг хэрэглэгчдийн цахим боловсрол, мэдлэгийг дээшлүүлэх шаардлагатай байна. Мөн хууль эрх зүйн орчныг боловсронгуй болгох, үндэсний кибер аюулгүй байдлыг бэхжүүлэх чиглэлээр арга хэмжээ авах шаардлагатай юм.

## ② Хүрээлэн буй орчинтой зохицсон эдийн засгийн тэнцвэртэй өсөлтийг хангах

- Нийслэл хотын хэт төвлөрөл (нийт хүн амын 50%), хотын захын гэр хорооллын замбараагүй тэлэлтээс шалтгаалсан түгжрэл, газар хөдлөлтийн стандарт хангахгүй хуучин барилгууд, хотын захад инженерийн дэд бүтэц (цэвэр, бохир ус, дулааны шугам сүлжээ) байхгүйгээс үүдсэн агаарын бохирдол зэрэг хотын орчны асуудал улам хурцдаж байна.
- Монгол Улсын тогтвортой хөгжлийг хангахын тулд уул уурхайгаас бусад салбарыг хөгжүүлэх шаардлагатай. Нийт ААНБ-ын 70%-ийг эзэлдэг жижиг дунд аж ахуйн нэгж эрхлэгчдийн дунд менежментийн мэдлэг, чадвар дутмаг хүн олон байдаг. ЖДҮ-ийг хөгжүүлэх замаар эдийн засгийг төрөлжүүлэх нь нэн тулгамдсан зорилт болоод байна.
- IT, ХАА, Аялал жуулчлалын салбарт цаашид ч дэмжлэг үзүүлнэ.

## ③ Хүртээмжтэй нийгмийг бий болгох

- Эрүүл мэндийн салбарын боловсон хүчнийг чадавхжуулах тогтолцоог бүрдүүлснээр эрүүл мэндийн тусламж үйлчилгээний түвшнийг сайжруулна. Хот, хөдөөд эрүүл мэндийн тусламж үйлчилгээний хүртээмж ихээхэн ялгаатай байгаа нь тулгамдаж буй асуудлуудын нэг юм.
- Нийгмийн хандлагын нөлөөнд өртөмтгий эмзэг бүлэгт (хөгжлийн бэрхшээлтэй иргэд, ядуу давхарга) боловсрол, нийгмийн халамж зэрэг нийгмийн суурь үйлчилгээг хангалттай хүртээх чиглэлд дэмжлэг үзүүлнэ.

# ЖАЙКА-ийн хамтын ажиллагааны үндсэн чиглэл



JCAP (JICA Country Analysis Paper※)-д (2022-2026) Монгол Улсын хөгжлийн үндсэн асуудлуудыг шийдвэрлэхэд чиглэсэн ЖАЙКА-ийн үндсэн чиглэлийг тодорхойлсон.

## Үндсэн чиглэл: Эдийн засгийн тогтвортой өсөлт, нийгмийн тогтвортой хөгжлийг хангах

Тэргүүлэх салбар	Хамтын ажиллагааны хөтөлбөр
Эрүүл макро эдийн засгийг бий болгоход чиглэсэн засаглалыг бэхжүүлэх	<ol style="list-style-type: none"><li>1. Төрийн санхүүгийн сахилга батыг бэхжүүлж, санхүүгийн системийг төлөвшүүлэх</li><li>2. Засаглалыг бэхжүүлэх</li></ol>
Хүрээлэн буй орчинтой найрсан зохицсон тэнцвэртэй эдийн засгийн хөгжлийг хангах	<ol style="list-style-type: none"><li>1. Байгаль орчин, гамшгаас сэргийлэх асуудлыг анхаарсан хотын дэд бүтцийг байгуулах</li><li>2. Эдийн засгийг төрөлжүүлэх, бүс нутгийн хөгжилд чухал үүрэгтэй үйлдвэрлэлийг хөгжүүлэх</li></ol>
Хүртээмжтэй нийгмийг бүтээх	<ol style="list-style-type: none"><li>1. Эрүүл мэндийн тусламж үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулах</li><li>2. Нийгмийн суурь үйлчилгээг бэхжүүлэх</li></ol>

※JCAP (JICA Country Analysis Paper) гэдэг нь ЖАЙКА-аас улс орон бүрийн хөгжлийн төлөө үр өгөөжтэй хамтран ажиллах боломжийг судлан, хэрэгжүүлэх үүднээс хийдэг дүн шинжилгээ юм. Японы Засгийн газраас баталдаг “Хөгжлийн хамтын ажиллагааны чиглэл” зэрэг тусламжийн бодлогыг боловсруулахад JCAP мэдээлэлээр хангадаг.



# 3.Томоохон төслүүд

## Тээвэр

Улаанбаатар хотын ОУ-ын нисэх онгоцны шинэ буудал барих төсөл (ХЗ + ТХА)



## Ашигт малтмал, эрчим хүч

Улаанбаатар “ДЦС-4”-ийн үр ашгийг дээшлүүлэх төсөл (ХЗ, БТ+ ТХА)



## Боловсрол

Инженер, технологийн дээд боловсролийг дэмжих төсөл (ХЗ)



## Эрүүл мэнд, боловсрол

Япон-Монголын Сургалтын эмнэлэг (БТ + ХА)



## Хувийн хэвшил

Монгол-Японы Хүний нөөцийн хөгжлийн төв (БТ+ ТХА)



## Боловсрол

Бага, дунд сургуулийн барилга байгууламжийг сайжруулах төсөл (БТ)





## Өнөөг хүртэл нийт 48 Техникийн Хамтын Ажиллагааны төслийг хэрэгжүүлсэн.

### Тээвэр

Монгол орны цаг уурын нөхцөлд тохирсон авто замын хучилтын технологийн чадавхийг сайжруулах төсөл



### Засаглал

Монголын татварын албаны татвар хураалтын үйл ажиллагаа болон олон улсын татварын асуудлыг боловсронгуй болгох нь төсөл



### Боловсрол

Монголын Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн хөгжлийн тусламж үйлчилгээг сайжруулах, эцэг эх, мэргэжилтнийг чадавхжуулах төсөл



### Эрүүл мэнд, боловсрол

Япон-Монгол Сургалтын Эмнэлгийн хүний нөөцийг чадавхжуулах, менежментийг төгөлдөршүүлэх төсөл



### Аялал жуулчлал

Тогтвортой аялал жуулчлалын бодлогын зөвлөх



### Гамшгаас хамгаалах

Улаанбаатар хотын газар хөдлөлтийн гамшгаас хамгаалах, урьдчилан сэргийлэх чадавхыг бэхжүүлэх төсөл







- Монгол улсад ЖАЙКА-ийн Хилийн чанад дахь сайн дурын хамтын ажиллагааны гишүүн илгээж эхэлсний 30 жилийн ой 2022 онд тохиосон. ЖАЙКА-ийн сайн дурын гишүүд Монгол ахуй дунд амьдарч, монгол хэлээр ярьж ойлголцон, хөгжлийн асуудлыг өөр нэг өнцгөөс шийдвэрлэх арга замыг эрэлхийлж байна. (\*2023.8.1-ний байдлаар 25 сайн дурын гишүүн ажиллаж байна.)
- 2023 оноос сайн дурын гишүүдийг томилох төлөвлөгөөг эргэн харж GA, кластерийн төслийн стратеги зэрэг ЖАЙКА-ийн бусад нөөц бололцоог харгалзан үзсэний үндсэн дээр томилон ажиллуулж байна.
- Аж үйлдвэрийн салбарын хүний нөөцийг хөгжүүлэх, дэд бүтэц, байгаль орчин, боловсрол, эрүүл мэнд, спорт, хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд болон иргэдэд дэмжлэг үзүүлэх зэрэг чиглэлээр 50~60 сайн дурын гишүүн илгээхээр төлөвлөн ажиллаж байна.



## **4. Хувийн хэвшлийн салбар, Мэдээлэл, харилцаа холбооны технологийн (ICT) салбарыг дэмжих үйл ажиллагаа**



# Монгол, Японы хувийн хэвшлийнхний бизнесийн түншлэлийг дэмжих үйл ажиллагаа



Монгол-Японы Хүний нөөцийн хөгжлийн төв  
(Буцалтгүй тусламж, Техникийн ХА)

Хүний нөөц  
(Мэргэжилтэн)  
бэлтгэх

Бизнесийн сургалт :  
◆ Оролцогч: 19,000 гаруй хүн  
◆ Хамрагдсан ААН: 500 гаруй



- Хөрөнгө оруулалтын орчны талаар мэдээлэл өгөх  
- Бизнесийн харилцаа

Инженер, технологийн дээд боловсролын төсөл  
(Хөнгөлөлттэй зээл)


Механик, Барилга, Эрчим хүч, цахим гм.  
- Хосолсон хөтөлбөр (Бакалавр) 320 хүн  
- Магистр, Доктор, Зэрэггүй: 480 хүн  
- Коосэн (дэд/бакалавр) 200 хүн

ЖДҮ-ийг дэмжих, байгаль орчныг хамгаалах 2 үе шаттай зээлийн төсөл  
(Хөнгөлөлттэй зээл)

- Зээл авсан ААН: 700 гаруй  
- Шинэ ажлын байр: 10,000 ХАА, Хүнс боловсруулах, барилгын материал, нэхмэл, аялал жуулчлал гм



Эх үүсвэрийн дэмжлэг (Зээл)



- Монголын ХО-ын орчныг сайжруулахад чиглэсэн үйл ажиллагаа
- Хөрөнгийн зах зээлийн чадавхийг бэхжүүлэх төсөл (ТХА)
  - Улсын хөрөнгө оруулалтын хөтөлбөр боловсруулах, чадавхи бэхжүүлэх төсөл (ТХА)
  - Шудрага өрсөлдөөний орчныг сайжруулах төсөл (ТХА)
  - Зээлийн батлан даалтын тогтолцоог сайжруулах (сургалт)

- Мэргэжилтэн илгээх  
- Сургалт зохион байгуулах гм

- Гадаадын ХО, санхүүжилт  
- Хувийн хэвшлийн түншлэлийн төсөл (суурь судалгаа, төслийн судалгаа, нэвтрүүлэх, туршилт, бизнес хөгжүүлэх гм)



## Бодлого, хууль эрх зүйн орчныг сайжруулах

ICT салбарын хөгжлийг дэмжих судалгаа 【Суурь судалгаа】

Кибер аюулгүй байдлыг бэхжүүлэх төсөл 【ТХА】



Засгийн газар



Үйлдвэрлэл

Боловсрол

## Үйлдвэрлэлийг хөгжүүлэх

ICT Гарааны бизнесийг дэмжих хөтөлбөр (MonJa) 【ТХХТ】

AI Business Contest (DX CUP) 【ТХХТ】


Цахим, Дэд бүтэц

Санхүүжилт зэрэг дэмжлэг

Хөрөнгө оруулалт



## Хүний нөөцийг хөгжүүлэх



Инженер, технологийн дээд боловсролыг дэмжих төсөл (Хөнгөлөлттэй зээл)

Өвсний үндэс : DX хүний нөөцийг хөгжүүлэх хөтөлбөр боловсруулах, Коосэнд сайн дурын ашигшүүн илгээх

Монгол-Японы Хүний нөөцийн хөгжлийн төв дээр явагддаг бизнесийн хүний нөөц, ААНБ-ын удирдлагад зориулсан мнэжементийн сургалт, хоёр орны ААН-үүдийг холбох үйл ажиллагаа



# Монгол-Японы Хүний нөөцийн хөгжлийн төв

Буцалтгүй тусламж

Техникийн ХА



- Монгол-Японы Хүний нөөцийн хөгжлийн төв нь ЖАЙКА-ийн Буцалтгүй тусламжаар МУИС-ийн дэргэд 2002 онд байгуулагдсан бөгөөд 2016 оны 4 сарын байдлаар үйлчлүүлэгчдийн тоо 2 саяд хүрсэн.
- Монгол Улсын зах зээлийн эдийн засгийн шилжилтэнд хувь нэмэр оруулах, хүний нөөцийг хөгжүүлэх, хоёр орны харилцааг дэмжих зорилгоор ① Бизнесийн хүний нөөцийг хөгжүүлэх, ② Япон хэлний сургалт, ③ Хоёр орны харилцан ойлголцлыг дэмжих үйл ажиллагааг хэрэгжүүлж байна.
- Монголын ААН-ийн удирдлагад зориулсан менежментийг сайжруулах бизнесийн сургалт явуулахын зэрэгцээ шинээр хоёр орны ААН хоорондын бизнесийн харилцааны тулгуур төв болох функцээ бэхжүүлэх зорилгоор Техникийн хамтын ажиллагааны төсөл хэрэгжүүлж байна.
- 2023 он 6 сард Монголын арилжааны банкуудтай (ХХБ, Голомт банк зэрэг) хамтран ажиллаж, Японы ICT, цахим салбарын 20 ААН-ийг Монголд урьж Япон, Монголын ААН-үүдийн “Business matching” уулзалтыг зохион байгуулсан.



- 2014 онд 7,5 тэрбум иенийн Хөнгөлөлттэй зээлийн хэлэлцээр байгуулсан. Инженер, технологийн дээд боловсролын байгууллага болох МУИС, ШУТИС–ийн чадавхыг бэхжүүлэх, Япон Улсад оюутан сургаснаар инженер технологийн хүний нөөцийг хөгжүүлэх зорилготой, Барилга, Архитектур, Механик, Цахилгаан эрчим хүч, МТ зэрэг аж үйлдвэрлэлийн салбарын хүний нөөцийг бэхжүүлэхэд чиглэсэн төсөл юм.
- ① Бакалаврын боловсролын чанарыг дээшлүүлэх зорилгоор Японы их сургуультай Хамтарсан хөтөлбөр,
- ② Багшийн боловсрол, судалгааны чадавхыг сайжруулах зорилго бүхий японд сургах (доктор, магистр, зэргийн бус) болон 26 сэдвээр хамтарсан судалгаа хийх хөтөлбөр,
- ③ Төгсөөд шууд ажил дээр гарах боломжтой Япон улсын Коосэн технологийн коллежид сургах хөтөлбөрийг хэрэгжүүлж байна.





# Мэдээлэл, харилцаа холбооны технологийн (ICT) салбарын суурь мэдээлэл цуглуулах судалгаа

Суурь судалгаа



- 2023.3-2025.4 сар хүртэл ICT, цахим салбар, гарааны бизнесийг дэмжихэд чиглэсэн мэдээлэл цуглуулах, тодруулах судалгааг хэрэгжүүлж байна.
- Дан ганц салбарын хараат байдлаас ангижрах зорилгоор 2020 оны 5-р сард УИХ-аас баталсан “Алсын хараа 2050” Урт хугацааны хөгжлийн баримт бичигт “2030 он гэхэд технологид суурилсан инновацийг бий болгохыг зорино” гэж заасан бөгөөд энэ хүрээнд ICT, цахим салбарыг бэхжүүлнэ гэж тусгасан байдаг.
- Монгол Улс болон сайн жишээ бүхий бусад орны ICT, цахим салбарын хөгжлийн түүх, ICT, цахим салбарын хүний нөөц, бизнес эрхлэгчдийн боловсрол, ажиллах орчин, Монгол Улсын Засгийн газраас хэрэгжүүлж буй Нисэх онгоцны шинэ буудал орчмыг хөгжүүлэх ажлын хүрээнд ICT, цахим салбарыг татах замаар ухаалаг хотыг хөгжүүлэх үйл ажиллагаа болон нээлттэй мэдээлэл (open data) ашиглахтай холбоотой мэдээллийг цуглуулж, дүн шинжилгээ хийж байна. Мөн олон төрлийн тусламж дэмжлэгийг хэрэгжүүлэх боломжтой эсэхийг шалгах туршилтын төслүүдийг хэрэгжүүлж байна.

Суурь судалгаа:  
Ажлын хэсэг байгуулах



Туршилтын төсөл ③  
Хурдасгуур хөтөлбөрийн (MONJA)  
үр дүнг баталгаажуулах



Туршилтын төсөл ①  
Япон-Монголын ICT компаниудын Business  
Matching-ийн үр дүнг баталгаажуулах




Туршилтын төсөл ④  
ICT чиглэлээр суралцагчийн сургалтын  
үр дүнг баталгаажуулах



Туршилтын төсөл ②  
ICT, дижитал хүний нөөцийн Job  
Seminar-ийн үр дүнг баталгаажуулах



Туршилтын төсөл ⑤  
Open data ашиглах ажлын үр  
дүнг баталгаажуулах



# MONJA Монголын гарааны бизнесийг дэмжих хурдасгуур хөтөлбөр



- ЖАЙКА нь Мобиком ХХК, Монгол Японы Хөгжлийн төвтэй хамтран гарааны бизнесийн компаниудыг сонгон шалгаруулж, менторинг, networking дэмжлэг үзүүлэх хурдасгуур хөтөлбөрийг 2020 оноос хэрэгжүүлж эхэлсэн бөгөөд одоогийн байдлаар 2 удаа зохион байгуулаад байна.
- MONJA-1 Цар тахлын үеийн нийгмийн асуудлыг шийдвэрлэх сэдвээр хөтөлбөрийг хэрэгжүүлсэн бөгөөд нийт 141 компаниас 4 компанийг (телемедицин, зайн сургалт, бизнесийн үйлчилгээ 2 компани) сонгон шалгаруулж, дэмжлэг үзүүлсэн.
- MONJA-2 SDGs-ийн зорилтыг хангахад дэмжлэг үзүүлэх зорилгоор шинэлэг бизнесийн загвар, технологийг бий болгосон мобайл аппликейшн гэсэн сэдвээр 60 компаниас 3 (хүүхэд харах үйлчилгээ, амьдралын суурь өвчнөөс урьдчилан сэргийлэх, цахим боловсрол) компанийг сонгож, хөтөлбөрт хамруулсан.
- MONJA-3 Өнөөдрийн (2023.8.18) "Монгол-Японы бизнес форум" дээр 3 дахь удаагийн хөтөлбөрт шалгарсан 3 компанийг танилцууна.



Logos: jica, mobicom, mojice, MOJIC

**MonJa Startup Accelerator Program  
in response to COVID-19**

**MONJA**

To support startups which are going to introduce innovative ideas for fighting against COVID-19, The Japan International Cooperation Agency (JICA), Mongolia-Japan Center (MOJC), and MobiCom Corporation (MobiCom) have announced the launch of the MonJa Startup Accelerator Program. Selected startups can join in the program and also get up to maximum of 30,000 USD for 6 months empirical surveys to verify whether the proposed business contributes to social issues.

**Maximum 30,000 USD/company**

**Supporting Program:** Mentoring service, lecture, networking and pitch event.



Logos: Deloitte, XZP, x° partners, jica, mobicom, MONGOLIA-JAPAN CENTER

**MONJA**  
MONGOLIA ACCELERATOR  
PROGRAM 3

APPLICATION DEADLINE: JULY 21, 2023





# DX CUP Бизнес загвар боловсруулах тэмцээн



- DX CUP нь Монгол Улсад Цахим шилжилт (DX)-ийг дэлгэрүүлэх, Мэдээлэл, харилцаа холбоо (ICT), цахим инженерчлэл, түүний хүний нөөцийг хөгжүүлэх зорилготойгоор цахим шилжилтийн технологийг ашиглан өрсөлдөх бизнес тэмцээн юм.
  - DX CUP 2023-т цахим шилжилтийн технологи буюу хиймэл оюун ухаан дээр нэмээд юмсын интернет (IoT), үүлэн технологи, метаверс гэх мэт цахим шилжилтийн бусад технологиудыг хамруулан Коосэн болон бакалаврын зэргээр суралцаж байгаа оюутнуудын дунд зохион байгуулсан. Монголоос нийт 40 баг оролцсоноос гадна анх удаа финалд Японоос хоёр баг оролцсон.
- ❑ **Зохион байгуулагч** : БШУЯ, Цахим шилжилтийг дэмжих холбоо,
  - ❑ **Дэмжигч байгууллага**: Японы гүн сургалтын холбоо (JDLA), Японы KOOCЭН сургуулийн холбоо, GOTANDA Valley
  - ❑ **Спонсор байгууллага**: Мобиком, Анд Глобал, Голомт Банк, Dentsu Data Artist Mongol, KITE, USP-Lab, NashaTech



MINISTRY OF  
EDUCATION AND  
SCIENCE



DX MONGOLIA



DENTSU  
DATA ARTIST  
MONGOL  
Data Driven Artistic Mongol



SocialPay



mobicom



AND GLOBAL  
A True Fintech Company



usp lab.



## 1-р байр: Монгол Коосэн Технологийн Коллежийн "WWSY" баг

Ус хэмнэгч ухаалаг төхөөрөмж: Ус дамжуулах хоолой дахь усны хэмжээг мэдрэгч ба хэмжилтийн датаг гар утасны аппликейшнд дамжуулдаг IoT төхөөрөмжийг бүтээсэн.

## 2-р байр: ШУТИС МХТСургуулийн "Хангарди" баг

AI дуудлагын төв: Товчлуурын оронд дуу хоолойгоор харилцдаг систем. Chat GPT-с ярианы үсгийг хөрвүүлдэг Chimege аппликэйшн болон CallPro үйлчилгээг ашиглан Эмнэлгийн цагийг дуу хоолойгоор дамжуулан систем бүртгэдэг.

## 3-р байр: ШУТИС-ийн Коосэний "SF" баг

AI дүрсийг таних замаар Хөдөлмөр хамгааллын хувцас өмссөн эсэхийг тогтоох төхөөрөмж.

# Mongolia Open Innovation and Co-Creation for SDGs: MICS

Суурь судалгаа




- ЖАЙКА-аас “Тогтвортой Хөгжлийн Зорилтуудыг хангахад чиглэсэн Монголын нээлттэй иноваци ба хамтын бүтээл” (Mongolia Open Innovation and Co-Creation for SDGs: MICS) арга хэмжээг зохион байгуулж байна.
- MICS нь олон талт оролцогч талууд Монголын нийгэмд тулгарч буй асуудлуудыг шийдвэрлэхийн тулд технологи, шинэ санаа, мэдлэг, туршлага, хөрөнгө нөөц бололцоог нэгтгэн иноваци болон хамтын бүтээлээр дамжуулан нийгмийн асуудлын шийдлийг олох хамтын ажиллагааны шинэ хөтөлбөр юм.
- Биечлэн болон онлайн платформ дээр харилцах замаар бусад байгууллагуудтай хамтран ажиллах багийг бүрдүүлнэ.
- Өчигдөр (2023.8.17) болсон анхны өдрийн арга хэмжээн дээр шалгарсан шилдэг санааг өнөөдрийн (2023.8.17) "Монгол-Японы бизнес форум" дээр танилцуулна.
- 2024.2 сар хүртэл үргэлжлэх энэхүү иновацийн үйл ажиллагааг хэрэгжүүлэх зардлын тодорхой хэсгийг ЖАЙКА хариуцаж байна.

❑ Оролцогч талууд: Япон-Монголын ААН, ТББ, орон нутгийн захиргаа, Их дээд сургууль, Коосэн, судалгааны байгууллага, хандивлагчид


❑ Арга хэмжээ: 2023.8.17 Matching event  
2023.8.18 Pitch event

Туушин Зочид буудал  
МҮХАҮТ

❑ Төлөвлөгөө:



Гэр хороллын асуудал



Автозамын түгжрэл



**5. ЖАЙКА-аас Японд гадаадаас ажиллах хүч хүлээж авах чиглэлээр үзүүлж буй дэмжлэг, хүйсийн тэнцвэртэй байдлыг хангах**



## JP-MIRAI гэж юу вэ ?

Япон Улсад ирдэг гадаад ажиллах хүчний асуудлыг шийдвэрлэхээр 2020 онд Хувийн хэвшил, Орон нутаг, ТББ, эрдэмтэн судлаач, өмгөөлөгч зэрэг олон талын төлөөлөл цуглаж байгуулсан сайн дурын нийгэмлэг юм.  
Гишүүдийн тоо: 666 байгууллага, хувь хүн (2023.7.28-ны байдлаар)



2020.11.16  
Анхдугаар хурал

## Оролцогчид ба бүтэц



## JP-MIRAI-гийн үйл ажиллагаа

“Бизнес ба хүний эрх” TX3 (SDGs)-ын дагуу үйл ажиллагаа явуулмаар байгаа хэдий ч компанийн боломжинд хязгаар байдаг.

Гадаад ажилчин авахтай холбоотой бусад ААНБ-ын үйл ажиллагааг мэдмээр байна.

Хамтдаа бүс нутгаа сэргээхийн төлөө гадаад ажилчдыг авмаар байвч бусад бүс нутгийн жишээнээс санаа авч юу хийж болохыг бодмоор байна.

**WITH MIGRANT WORKERS**  
Гадаад ажилчидтай мэдээлэл хуваалцаж, харилцан туслалц

**WITH PRIVATE SECTORS**  
“Бизнес ба хүний эрхийн” чиглэлээр хамтран ажиллах

**WITH MULTI-STAKEHOLDERS**  
Харилцан суралцах, дотоод, гадаад руу мэдэгдэх

Японы эдийн засан, нийгмийн чухал бүрэлдхүүн хэсэг болох гадаад ажилчдыг оролцуулсан “Зохистой хөдөлмөр эрхлэлтийг” Decent work \*1 бий болгох

**Япон орныг зорьсон үйл хэрэгт JP-MIRAI хүчин чармайлт гаргана зүтгэх болно.**



\*1 Decent work: Эдийн засгийн хүртээмжтэй, тогтвортой өсөлт, хүн бүрийн бүтэн цагийн бүтээлт, урамтай, зохистой хөдөлмөр эрхлэлт



# JP-MIRAI портал (application)



Японд ажиллаж амьдрахад хэрэгтэй мэдээлэл, дэмжлэг үзүүлэх арга хэрэгслийн талаар олон хэлээр мэдээлэл өгнө!



## 【オンцлог 1】

Гадаадад (илгээгч оронд) нэвтрүүлснээр Япон орны сэтгэл татам тал, карьерийн хөгжил, ажиллах хүчнийг хэрхэн зохистой илгээх тухай мэдээллийг олгоно.

## 【オンцлог 2】

Японы дахь ажил, амьдралд шаардагдах мэдлэгийг ойлгомжтой тайлбарлаж, Засгийн газрын байгуулгын цахим хуудас руу хөтлөнө.

## 【オンцлог 3】

Цаг агаарын мэдээ, гамшгийн тухай мэдээ зэрэг өдөр тутам холбогдож болох контентийг олгоно.

## 【オンцлог 4】

“JP-MIRAI Аюулгүй байдал” хялбар асуултад хариулснаар гадаад ажилчин өөрийнхөө ажил амьдралын орчны аюулгүй байдлыг хянана. Хэрэв асуудал байвал зөвлөгөө өгдөг “JP-MIRAI Тусламж” руу хөтлөнө. ※ Японд ирсэн хүмүүст зориулсан.



# Японы орон нутгийн захиргаа, Монгол-Японы хүний нөөцийн хөгжлийн төв хамтран зохион байгуулдаг гадаадын хүний нөөцтэй холбоотой арга хэмжээ



- Монгол-Японы хүний нөөцийн хөгжлийн төв (MOJC) нь аж үйлдвэрийн хүний нөөцийг сургах үүднээс Японд ажиллах сонирхолтой хүмүүст зориулсан төрөл бүрийн арга хэмжээг зохион байгуулдаг.
- 2020.12 сард Ибараки муж болон ЖАЙКА нь гадаадын хүний нөөцийг хүлээн авахад дэмжлэг үзүүлэх чиглэлээр хамтран ажиллах тухай санамж бичиг байгуулсан.
- Энэ хүрээнд Ибараки муж, ЖАЙКА-ийн Цукуба төв, Монгол-Японы хүний нөөцийн төв хамтран Японы үйлдвэрлэлийн салбарын ЖДҮ-т ажиллаж байхдаа олж авсан мэдлэг туршлага нь эх орондоо буцаж ирсэний дараа ажил амьдралд хэрхэн тус болж байгааг харуулах зорилгоор Японд сургууль төгсөгчдийн JUGAMO нийгэмлэгийн оролцоотойгоор Японд сургууль төгсөөд эх орондоо буцаж ирсэн иргэд болон Японы ЖДҮ-үүдийн хооронд санал солилцох уулзалт зохион байгуулсан.



ЖАЙКА-ийн Төлөөлөгчийн газрын орлогч дарга Ёшимура мэндчилгээ дэвшүүлэв.



МЯТөвийн Накамура мэргэжилтэн, JUGAMO нийгэмлэгийн гүйцэтгэх захирал З.Сугар нар танилцуулга хийв.



ЖАЙКА Цукуба төвийн төлөвлөлт харицусан ажилтан Хатано



Ибараки Мужийн ААН-үүд ба Японд төгсөгчид санал солилцож байгаа нь



- Жендерийн үзэл баримтлалыг хэрэгжүүлэхийн тулд **жендертэй холбоотой төслийн тоог хангалттай болгож, чанаржуулахыг** зорино.
- Жендерийн төсөл:
  1. Жендерийн эрх тэгш байдал ба эмэгтэйчүүдийг эрх мэдэлжүүлэх явдлыг гол зорилго болгон хэрэгжүүлж буй төсөл
  2. Гол зорилго нь биш боловч Жендерийн тэгш байдал ба эмэгтэйчүүдийг эрх мэдэлжүүлэхэд чиглэсэн үйл ажиллагааг багтаасан төсөл

## 1.-ийн төслийн жишээ



Жендерийн хүчирхийллийн хохирогчдод дэмжлэг үзүүлэх орон нутгийн манлайлагч эмэгтэйчүүдийг бэлтгэх. (Шриланка)

Жендерийн төслийн эзлэх хувийн (тооны) талаарх зорилго

	5 дугаар дунд хугацааны төлөвлөгөөний зорилт (2026 он хүртэл)	Глобал хөтөлбөрийн зорилт (2030 он хүртэл)
ЖАЙКА-ийн нийт төсөл (ТХА, зээл, буцалтгүй тусламж) -д эзлэх хувь	40%	2022 онд 39% 80%
Сургалт, гадаадад суралцах төсөл Эмэгтэйчүүдийн хувь	40%	2022 онд 38% 50%

## 2.-ын төслийн жишээ



Дели хотын метро нь эмэгтэйчүүдэд зориулсан хэсэгтэй. (Энэтхэг)



Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн боловсролыг сайжруулах төсөл (2-р шат)

Хэрэгжиж буй


Хөгжлийн бэрхшээлтэй сурагчийн хэрэгцээг хүйс тус бүрээр нь тодруулж, гарын авлага ба сургалт зэрэг үйл ажиллагааны агуулгад тусгана.

## **6. ЖАЙКА-аас хэрэгжүүлж буй хувийн хэвшлийн түншлэлийг дэмжихэд чиглэсэн үйл ажиллагаа**

# Хувийн хэвшлийн түншлэлийг дэмжих үйл ажиллагаа

“ЖДҮ болон Тогтвортой хөгжлийн зорилтыг хангахад чиглэсэн бизнесийг дэмжих үйл ажиллагаа” гэдэг нь хөгжиж буй орнуудад тулгамдаж байгаа асуудлыг шийдвэрлэхийн тулд Японы ААН-ын оролцоог дэмжихэд чиглэсэн үйл ажиллагаа юм.

ЖАЙКА нь Хөгжлийн Албан Ёсны Тусламж (ODA)-аар дамжуулан хөгжиж буй орнуудтай бий болгосон харилцаа, итгэлцэл, how how-г ашиглан үнэ цэнийг хамтдаа бүтээхийг зорьдог.



# Дэмжлэгийн хэлбэрүүд

Суурь мэдээлэл цуглуулах

Бүтээгдэхүүн, үйлчилгээ нь тухайн орны хэрэгцээнд нийцэх эсэхийг судлах

Бизнесийн хувьд хөлөө олж, үргэлжлэх эсэхийг судлах

Бүтээгдэхүүн, үйлчилгээ нийлүүлэх тогтолцоо, менежментийг бий болгох

Бизнес хийж эхлэх

Бизнес хөгжүүлэлтийг дэмжих хэлбэр

Шинэ систем

**Эрэлтийн судалгаа**

- Суурь мэдээлэл цуглуулж, Хөгжиж буй орны хэрэгцээ шаардлагад өөрийн компанийн бүтээгдэхүүн үйлчилгээ нийцэх эсэхийг судлах.
- Анхан шатны бизнес төлөвлөгөө боловсруулах.
- Хугацаа: 8 сар орчим

**ЖДҮ, дундаж орлогтой компаниуд, Стартапууд**

- Дээд тал нь 10 сая иень
- Зөвлөх үйлчилгээ (4 хүн сар орчим )

Судалгаа захиалж хийлгэх хэлбэр

**Нэвтрүүлэх, турших, бизнес хөгжүүлэх төсөл**

- Технологи, бүтээгдэхүүн болон бизнес загварыг туршиж нэвтрүүлэх үйл ажиллагаагаар дамжуулан бизнес төлөвлөгөө боловсруулах
- Хугацаа: 1-3 жил орчим

**ЖДҮ-ийг дэмжих хэлбэр**

- Дээд тал нь 100, 150, 200 сая иень
- Зөвлөх үйлчилгээний зардал багтсан.

**ТХЗ-ын хэрэгжилтийг хангах бизнесийг дэмжих хэлбэр**

- Дээд тал нь 50 сая иень
- Зөвлөхтэй холбоотой зардал багтсан.

Бизнес хөгжүүлэлтийг дэмжих хэлбэр

Шинэ систем

**Бизнес хөгжүүлэлтийг баталгаажуулах төсөл**

- Бүтээгдэхүүн үйлчилгээний талаарх хэрэглэгчийн хүлээлтийг судалж, тухайн орондоо түнш хамтрагчтай болж, бизнес загвар боловсруулан үр ашгийг нягталж, бүтээгдэхүүн үйлчилгээ үзүүлэх тогтолцоо, менежментийг бүрдүүлэх.
- Хугацаа: 1.4 жил орчим

**ЖДҮ, дундаж орлогтой компаниуд, Стартапууд, томоохон аж ахуйн нэгжүүд**

- Дээд тал нь 20 сая иен
- Зөвлөхийн үйлчилгээ (8 хүн сар орчим )

Өөрийн компанийн бизнесийг хөгжүүлэх



ЖАЙКА-ийн төсөлтэй холбогдох

# Дэмжлэг авах боломжтой хуулийн этгээд

Энэхүү дэмжлэгийн төсөл нь **Японд хүчин төгөлдөр мөрдөгдөж буй хууль тогтоомжийн дагуу бүртгэгдсэн хуулийн этгээдэд** хамааралтай бөгөөд хүсэлт гаргаж байгаа аж ахуйн нэгжийн ангиллаас хамаарч дэмжлэг үзүүлэх хэлбэр нь ялгаатай байдаг. Хамтарсан түншлэл болж “Эрэлтийн судалгаа” эсвэл “Нэвтрүүлэх, турших, бизнес хөгжүүлэх төсөл (ЖДҮ дэмжих хэлбэр)”-д хүсэлт гаргасан бол түншлэлд багтсан бүх аж ахуйн нэгж нь холбогдох хуулийн этгээдийн шаардлагыг хангасан байх шаардлагатай байдаг.

Хуулийн этгээдийн ангилал		Бизнес хөгжүүлэлтийг дэмжих хэлбэр		Судалгаа захиалж хийлгэх хэлбэр	
		Эрэлтийн судалгаа	Бизнес хөгжүүлэлтийг баталгаажуулах төсөл	Нэвтрүүлэх, турших, бизнес хөгжүүлэх төсөл	
				ЖДҮ-г дэмжих хэлбэр	ТХЗ-ыг хангахад чиглэсэн бизнесийг дэмжих
<span style="background-color: #e91e63; color: white; border-radius: 50%; padding: 2px 5px;">Стартап орно</span> Ашгийн төлөө хуулийн этгээд	ЖДҮ, дундаж орлоготой ААН	●	●	●	
	Бусад		●		●
Ашгийн бус хуулийн этгээд		●	●		●
ЖДҮ-ийн холбоо		●	●	●	

ЖДҮ: Японы ЖДҮ-н тухай хуулийн 2.1~4-д заасан ААН  
 Дундаж орлоготой ААН: Салбараас үл хамааран 1 тэрбум хүртэл иений дүрмийн сантай ААН  
 Ашгийн бус хуулийн этгээд: Нэгдсэн холбоод, Сургуулиудын холбоод, Эмнэлгүүдийн холбоод, ТББ, АТББ  
 ЖДҮ-ийн холбоо: Бизнесийн хоршоо, бизнесийн холбоо, эвлэл, худалдаа үйлдвэрлэлийн танхим  
 SU: Стартап (Байгуулагдаад 15 жил болоогүй, хувьцаа гаргаагүй стартапад үзүүлэх дэмжлэг  
 ※5 сая иенээс дээш)

※Венчур капиталаас хөрөнгө оруулалт хийсэн байдал, Засгийн газрын байгуулгаас олгосон дэмжлэг, захиалгат ажил

# Сонгон шалгаруулалтын ТОВ (урьдчилсан байдлаар)



“Эрэлтийн судалгаа”, “Бизнес хөгжүүлэлтийг баталгаажуулах төсөл”, “Нэвтрүүлэх, турших, бизнес хөгжүүлэх төсөл (ЖДҮ-г дэмжих хэлбэр ТХЗ бизнесийг дэмжих хэлбэр)”-ийн сонгон шалгаруулалтыг доорх хуваарийн дагуу явуулдаг.

Сонгон шалгаруулалтыг 9 сарын 1-нд зарлах бөгөөд мөн ондоо багтаагаад тэнцсэн эсэх талаарх хариуг (Е-мэйл) мэдэгдэнэ. Санал ирүүлэх хугацааны дотор тусгай сайтаар (Өргөдөл гаргах удирдамжийн дагуу) саналаа ирүүлэх ёстой байдаг.

Хуваарь	Агуулга
8 сарын 1	Урьдчилсан шалгаруулалт зарлах
8 сарын 25	Урьдчилсан хүсэлт хүлээн авах эцсийн хугацаа
8 сарын 31	Урьдчилсан зөвлөгөө авах эцсийн хугацаа
<b>9 сарын 1 (урьдчилсан байдлаар)</b>	<b>Шалгаруулалт зарлах</b>
9 сарын 1 ~29 (урьдчилсан байдлаар)	Шалгаруулалттай холбоотой асуулт, хариулт Q&A
<b>9 сарын 29-ний 12:00 (урьдчилсан байдлаар)</b>	<b>Санал хүлээн авах эцсийн хугацаа</b>
10 сарын 10~12 сарын 20	ЖАЙКА үнэлгээ хийнэ
<b>12 сарын эцэс</b>	<b>Хариу мэдэгдэнэ.</b>





Энэхүү материалтай холбоотой  
тодруулгыг дараах хаягаар авна уу!



独立行政法人国際協力機構

モンゴル事務所

JICA MONGOLIA OFFICE


Shangri-la Centre, 19th and 21st Floor, 19A Olympic Street, Sukhbaatar  
District-1, Ulaanbaatar 14241 Mongolia TEL:75058778

# Хавсралт



- Монгол Улсын Засгийн газраас макро эдийн засгийн удирдлагыг тогтвортой болгох үүднээс “Төсвийн тогтвортой байдлыг хангах, төсвөөс гадуурх зарлагыг зогсоох, төсвийн хөрөнгө оруулалттай холбоотой бодлого, төлөвлөгөөг сайжруулснаар үр нөлөөг дээшлүүлэх” зорилгыг 2016 онд баталсан Дунд хугацааны хөгжлийн бодлогод тусгасан байна.
- Бүтээн байгуулалтын төслүүдийн өсөн нэмэгдэж буй хэрэгцээг хангахын тулд хязгаарлагдмал санхүүгийн эх үүсвэрийг хэрхэн хуваарилах, улсын төсвөөс гадуурх хөрөнгийг хэрхэн бүрдүүлэх зэрэг асуудлууд тулгарсан .
- Төсвийн хөрөнгө оруулалтын хөтөлбөрт төсөл сонгон шалгаруулах шалгуур үзүүлэлтийг тогтоох, төсөл боловсруулах, төслийн үнэлгээ хийх, санхүүгийн эх үүсвэрийг баталгаажуулах, төслийн мониторингийн механизмыг бий болгох замаар улсын хөгжлийн бодлого, санхүүгийн эх үүсвэрт нийцсэн төсвийн хөрөнгө оруулалтын хөтөлбөрийг боловсруулах, удирдах тогтолцоог бүрдүүлэхийг зорино.


## Улсын хөрөнгө оруулалтын хөтөлбөрийн(PIP) зорилго ба чиг үүрэг



## Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хуульд заасан Улсын хөрөнгө оруулалтын хөтөлбөрийн хууль эрх зүйн байр суурь



- Эдийн засаг хурдацтай өсөхийн хамт нийслэл Улаанбаатар хотод хүн ам, аж үйлдвэр (нийт хүн амын 46 орчим хувь, аж ахуйн нэгжийн 62 орчим хувь) төвлөрч, дэд бүтцийн хомсдол, хүрээлэн буй орчны бохирдол зэрэг хотын асуудал ужгирсан. Нөгөө талаар орон нутагт үйлчилгээний чанар муудаж, баян ядуугийн ялгаа ихсэж, хөдөлмөр эрхлэх боломж багасах зэргээр нийслэл ба орон нутгийн хооронд бүс нутгийн ялгаа гарч ирсэн.
- Улс орны ирээдүйн дүр төрх, түүнд хүрэх замыг харуулсан төлөвлөгөө боловсруулах, төлөвлөгөөг тасралтгүй боловсруулах, шинэчлэх чадавхийг бэхжүүлэх зорилгоор "Үндэсний хөгжлийн цогц төлөвлөгөө боловсруулах төсөл"-ийг хэрэгжүүлсэн. Улс орны тэнцвэртэй, тогтвортой хөгжлийг дэмжих, бүс нутгийн хоорондын ялгааг багасгах, нийслэлийн хотын асуудлыг шийдвэрлэхэд хувь нэмэр оруулсан.
- 2023 оны 1 сард Орхоны хөндийд хот байгуулах тухай" Улсын Их Хурлын тогтоолын төслийг өргөн мэдүүлж, баталсан бөгөөд энэ ажилд төслийн үр дүнг ашигласан болно.



## Чухал асуудал

Нэг туйлт төвлөрлийн бүтэц, тэгш бус байдлыг өөрчлөх / Хөдөө орон нутагт хүн ам багасах үед авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээ, хөдөө орон нутагт суурьшлын бүсийг батлан хамгаалах зорилгоор хадгалж байгаа байдал, хөрш орнуудтай эдийн засгийн тэнцвэртэй харилцаа тогтоох/ ур амьсгал, үндэс угсааны олон талт байдал, түүх, үнэт зүйлс үндэсний шинж чанарыг анхаарах

## Нөлөөл ба нэмүү өртөг

- Газар төлөвлөлтөд дэмжлэг үзүүлсэн: Улс орны ирээдүйн дүр төрхийг салбар дундын болон урт хугацааны хэтийн төлөвөөс авч үзсэн
- Монгол Улстай хамтын ажиллагааг өргөжүүлэх: Хувийн хэвшил болон төрийн сангийн эх үүсвэрийг тооцоолон үндэсний хэмжээний гол төслүүдийг санал болгохоор төлөвлөсөн (хувийн хэвшлийн хэрэгцээг тусгах тал дээр анхаарах). Төлөвлөлтийн процес: Бүс нутгийн ялгаатай байдлыг арилгах үүднээс бүх аймагт (21 аймаг) оролцогч талуудын уулзалтыг зохион байгуулж, орон нутгийн саналыг цуглуулсан.

## Хамтын ажиллагааны тойм

Судалгааны хугацаа: 2018 оны 11 сар~2021 оны 6 сар (32 сар)

Хамтран ажилласан байгуулга: БХБЯ (MCUD), ҮХГ (NDA)

Хамрагдсан газар нутаг: Монгол улсын нийт нутаг дэвсгэр (1,564,100km<sup>2</sup>)

## Үр дүн:

- ① Үндэсний хөгжлийн цогц төлөвлөгөө боловсруулагдсан.
- ② Төлөвлөлт хариуцсан байгууллагын чадавхи бэхжсэн



# Улаанбаатар “ДЦС-4” –ийн үр ашгийг дээшлүүлэх төсөл

Буцалтгүй тусламж

Хөнг/Зээл

ТХА




- УБ хотын эдийн засгийн өсөлт, хүн амын төвлөрөлөөс шалтгаалан дотоодын үйлдвэрлэлээр эрчим хүчний хэрэгцээг хангах боломжгүй болж, хөрш орнуудаас импортлох эрчим хүчний хэмжээ нэмэгдэж байна. Хойшид цахилгаан эрчим хүчний хэрэгцээ жилд 6-7%-иар нэмэгдэх төлөвтэй байна.
- Япон улс ДЦС-4 ТӨХК-д 1992 оноос хойш буцалтгүй тусламж, иений хөнгөлөлттэй зээлээр тоног төхөөрөмж сайжруулах төсөл хэрэгжүүлж, мэргэжилтэн, сайн дурын ажилтан илгээсэн.
- 2013 оны 11 сард Зээлийн гэрээг байгуулж, зуухны тоос бэлтгэх тоноглолын тээрмийн бул, таваг шинэчлэх, зууханд үнс үлээлгийн төхөөрөмж суурилуулах ажлыг Мицүбиши Хитачи Повер систем компани, уурын турбинуудын тохируулгын системийг шинэчлэх, хяналт удирдлагыг электрон системд шилжүүлэх ажлыг Ёкокава Дэнки компани гүйцэтгэж, суурилуулалтын ажил 2020 онд дууссан.



# Улаанбаатар хотын агаарын бохирдлыг бууруулах төсөл

- Улаанбаатар хот нь сүүлийн жилүүдэд цахилгаан станц болон автомашинаас гарч буй хаягдал утаа тортог, өвлийн цагт гэр хороолол дахь нүүрсний шаталтаас үүсэх утаа, тортог нь томоохон асуудал болж буй. Хотгор газарт орших хотын дээгүүр утаа хуримтлагдсаны улмаас агаарын бохирдлын асуудал иргэдийн эрүүл мэндэд хор уршиг учруулах аюултай.
- Агаар орчны хяналтын цикл (агаарын бохирдлын эх үүсвэрийн дүн шинжилгээ – арга хэмжээг судлах – арга хэмжээг үнэлэх – арга хэмжээг хэрэгжүүлэх)-ийг бий болгохоор 2010 оноос 2 үе шаттай техникийн хамтын ажиллагааны төслийг эхлүүлсэн бөгөөд одоо 3 дахь шатны төслийг хэрэгжүүлж байна.
- Өнөөг хүртэл агаарын чанарын үнэлгээг хийх технологийг нутагшуулах, хэмжилтийн мэдээлэл баримтад үндэслэн авах арга хэмжээний төслийг боловсруулах, иргэдэд мэдээлэл хүргэх зэрэг чиглэлээр үр дүнтэй ажилласан. , иргэдэд мэдээлэл хүргэх чиглэлээр үр дүнтэй ажилласан.
- Хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд Японд үйлдвэрлэсэн DPF (хар утаа тортогны шүүлтүүр) -ийг нэвтрүүлэн нийтийн тээврийн хаягдал утааг бууруулах, газрын дулааны халаалтын помп суурилуулан хүрээлэн буй орчинд ээлтэй халаалтын системийг нэвтрүүлэх, дулаан хадгалах будаг ашиглан нүүрсний хэмжээг багасгах зэрэг судалгааг хийсэн.

Агаар бохирдуулагч эх үүсвэрийн нэг болох нүүрсний зуухны оронд сэргээгдэх эрчим хүчийг нэвтрүүлэв.



Нийтийн тээврийн автобусанд DPF тортогийн шүүлтүүр суурилуулан туршив.



Зуны Улаанбаатар



Өвлийн Улаанбаатар






## Түүх, байгаль орчин

### Хархорин орчим

ЖАЙКА-ийн өмнө хийгдсэн судалгаанаас харахад АЖ-ыг хөгжүүлэх орон нутгийн үйлдвэрлэлд үр дүнтэй гэгддэг. Түүхэн АЖ-ын бүтээгдхүүн ихтэй ба алдартай газруудын нэг хэдий ч хүний нөөцийг хөгжүүлэх асуудал тулгамдаж буй.

Гол газар: Хархорин (Эрдэнэзуу, Хархорин музей), Орхоны хүрхрээ, Онги туурь, Цэцэрлэг гм

## 75. Area Development Programs of Integrated Regional Development Program



Хөгжлийн төлөвлөгөөнд тусгагдсан төсөл (2018~2021) Эцсийн тайлангаас ашиглав

## モンゴル国地域総合開発情報収集・確認調査2015 課題解決方針提案

### 3. 自然・文化資源保全

観光クラスター形成例：経済回廊を考慮した段階的整備計画の策定・実施が必要



Монгол улсын бүсчилсэн хөгжлийн ерөнхий төлөвлөгөөний суурь судалгаа (2015~2016)

Бизнес (Шинэ зуунмод, Зуун мод), байгаль (Тэрэлж)

УБ хот орчим (Зуунмод, Шинэ Зуунмод, Тэрэлж)

Монголын тал хувь нь оршин суух УБ-аас жуулчдаас гадна Өмнөговь, Хархорин болон Дорноговь маршрутаар дайран өнгөрөх тул ихээхэн танигдсан байдгаас хүлээлт их байна.

Түүх, байгаль, эртний олдвор

Сайншанд болон Замын-Үүд орчим (Дорноговь аймаг)

УБ-аас төмөр замтай давуу талыг ашиглан АЖ-ыг хөгжүүлэх талаар судалж буй. Дорноговь аймаг явах замд Чойр хотын хөгжлийн талаар ч судалж буй.

Гол газар: Хамрын хийд, Дэлхийн энергийн төв, гм

## Байгаль, эртний олдвор, геологи

### Даланзадгад, Өмнөговь аймаг

Олон тооны АЖ-ын нөөц баялаг ихтэй ч гадаадаас орох хаалга болох УБ-с зам харилцаа хязгаарлагдмал тул АЖ-ын баялаг хэдий ч АЖ-ын үйлдвэрлэлд шууд уялдаж чаддаггүй. Байгаль орчныг тооцсон АЖ-ыг хөгжүүлэх хэрэгцээ бий. Чулуужсан яс зэрэг ихтэй.

Гол газар: Молцог элс, Хонгорын элс, Баянзаг, Говийн байгалийн музей, Ёлын ам, Өмнөговь аймгийн музей гм

### Мандалговь хот, Дундговь аймаг


Өмнөговь аймаг руу явах замд таарах нутаг ба Мандалговь хот орчмын АЖ-ыг хөгжүүлэх ажил явагдаж байгаа ба Монголын өмнийг зорьсон жуулчдын урсгалыг татахаар найдлага тавьж буй.

Одоогоор Дорноговь орчмын жуулчны бааз байдаг ч бусад АЖ-ын бүсээс гадуурхагдах асуудал бий. Дуу хуурын нутаг хэмээн алдартай.

Гол газар: Дундговь музей, Их газрын чулуу, Үүш манхан гм (Дундговь музейгээс бусад нь хотоос 70 км гаруй зайтай оршино)


# ЖДҮ-ийг дэмжих, байгаль орчныг хамгаалах 2 үе шаттай зээлийн төсөл

- Монгол Улсын эдийн засаг уул уурхайн салбараас хэт хамаарсан бүтэцтэй тул төрөлжүүлэн хөгжүүлэх шаардлага тулгаад байгаа. Арилжааны банкны зээл үндсэндээ уул уурхай гэх мэт тодорхой салбар, томоохон компаниудад л олддог. Зээлийн хүү өндөр (дунджаар 20%), хугацаа богино, барьцаа өндөр, банкны үнэлгээний чадвар дутмаг зэргээс шалтгаалан уул уурхайн бус салбарт үйл ажиллагаа явуулдаг ЖДҮ-үүдэд зээлийн санхүүжилт илэрхий дутагдаж байна.
- Энэхүү төслөөр “Өсч дэвжих санхүүжилт” буюу хөнгөлөлттэй зээлийг өнгөрсөн 11 жилийн хугацаанд арилжааны банкуудаар дамжуулан нийт 700 орчим ЖДҮ-д олгоод байна. Нийт 21 аймагт зээлийн төслийг өргөжүүлж, 10 мянга гаруй хүний ажлын байр бий болгоход хувь нэмэр оруулсан. Мөн зээлдэгч ААН-ийн үндсэн зээл, хүүгийн төлбөрөөс эргэлтийн санд хуримтлуулж, дахин зээл олгож байна. .
- Зээлдэгчдийн ихэнх нь хөдөө аж ахуй, хүнсний үйлдвэрлэл, барилгын материалын үйлдвэрлэл, хувцас үйлдвэрлэл, аялал жуулчлал зэрэг үйлдвэрлэл, үйлчилгээний салбарынхан байгаа бөгөөд импортыг орлох, экспортыг хөгжүүлэхэд хувь нэмрээ оруулж байна



- Монгол улсын ХАА-н салбар нь 2017 оны байдлаар ДНБ-ний 10,6% (уул уурхайн дараа) ,ажиллах хүчний 30 орчим хувийг эзэлдэг эдийн засгийн үндсэн салбарын нэг юм.
- Өнгөрсөн жил ашигт малтмалын үнийн хэлбэлзлээс шалтгаалан эдийн засаг таагүй байсанаас үүдэн ХАА нь эдийн засгийг төрөлжүүлэхэд чухал үүрэгтэй салбар хэмээн анхаарал татаж, Монгол Улсын Засгийн газар ч ХАА-н түүхий эд, бүтээгдхүүний боловсруулалтыг дэмжих, экспортыг хөгжүүлэх бодлого хэрэгжүүлж байна. ЖАЙКА өнгөрсөн хугацаанд мал эмнэлэг, МАА-н салбарын хүний нөөцийг сургах, чадавхжуулах, малын эгэл биетний өвчний тархварын судалгаа хийх, нийгэмд нэвтрүүлэх боломжтой оношлогооны аргазүйг боловсруулах чиглэлээр ТХА-ны хүрээнд дэмжлэг үзүүлж ирсэн.
- 2019 оноос хэрэгжиж эхлэсэн шинэ төслөөр дараахь гурван чиглэлийн үйл ажиллагаагаар дамжуулан ХАА-н бүтээгдэхүүний өрсөлдөх чадварыг бэхжүүлэн улмаар ХАА-н үйлдвэрлэлийг тогтвортой хөгжүүлэхэд хувь нэмэр оруулахыг зорьж байна.

1. ХАА-н нэмүү өртөгийн сүлжээний хөгжлийг хариуцсан Засгийн газрын байгуулга болон мэргэжлийн холбоодын чадавхийг бэхжүүлэх
2. ХАА-н нийлүүлэлт, нэмүү өртөгийн сүлжээний үе шат (үйлдвэрлэл, боловсруулалт, түгээлт, борлуулалт) бүрт бий болж байгаа бизнесийн шинэ загварыг дэмжин, тэдгээрийн сайн жишээнд дүн шинжилгээ хийх
3. Монголын ХАА-н салбар болон холбогдох ААН-үүдийн дотоод, гадаадын зах зээл дээр өрсөлдөх чадварыг бэхжүүлэхэд хувь нэмэр оруулахуйц Ерөнхий төлөвлөгөө боловсруулах






# Монгол-Японы сургалтын эмнэлэг

無償資金協力

技術協力



- 2015 онд буцалтгүй тусламжийн гэрээ байгуулсан уг төслийн өртөг 8.4 тэрбум иень юм. Эмнэлгийн барилгын ажлыг Канто Кэнсэцу Коогёо (байгууламж), Марубэни Протекс (тоног төхөөрөмж) компани, зөвлөх үйлчилгээг Ямашита Сэkkэй, Азүса Сэkkэй, CDC Интернэшнл компаниудын консорциум гүйцэтгэсэн. 2019 оны зун барилгын ажил дуусч, намар нь амбулаторийг нээснээр үйл ажиллагаагаа эхлүүлсэн.
- Монголын хамгийн анхны Их сургуулийн эмнэлэг бөгөөд их сургуулийн эмнэлгийн стандартын байгууламж, тоног төхөөрөмжтэй.
- Эрүүл мэндийн салбарын боловсон хүчний төгсөлтийн дараах сургалтын түшиц эмнэлэг болгохын зэрэгцээ хүн амын шилжилт хөдөлгөөн ихтэй, эмзэг давхарга бүхий УБ хотын захын хорооллын иргэдэд эмнэлгийн тусламж үйлчилгээг хүргэхэд хувь нэмрээ оруулж байна.
- Эрүүл мэндийн салбарт ① Эмч, сувилагчийн төгсөлтийн дараах сургалтыг чанаржуулах, хөтөлбөр, сургалтын материалыг сайжруулах, ② Эмнэлгийн менежментийг сайжруулах, эрүүл мэндийн тусламж үйлчилгээ үзүүлэх тогтолцоог боловсронгуй болгох техникийн хамтын ажиллагааг хэрэгжүүлж байна.



# Бага, дунд сургуулийн барилга барих төсөл

Буцалтгүй тусламж



- Японы Засгийн газраас Улаанбаатар хотод 59 бага, дунд сургуулийн барилгыг шинээр барьж, өргөтгөж, боловсролын орчныг сайжруулахад хувь нэмэр оруулаад байна.
- Хамгийн сүүлд ЖАЙКА-ийн буцалтгүй тусламжаар Улаанбаатар хотод 2 сургууль (75-р сургууль, 149-р сургууль) шинээр барьж, 2 сургуулийг (53-р сургууль, 109-р сургууль) өргөтгөсөн болно. Энэхүү төсөл нь 2018-2021 онд хэрэгжсэн бөгөөд төслийн өртөг нь ойролцоогоор 2.3 тэрбум иень (20 сая орчим ам.доллар) юм.
- Эдгээр сургуулийн барилгын хувьд хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд тохиромжтой байхад анхаарч, гамшгаас сэргийлэх, байгаль орчинд ээлтэй байх талаас барилгын зураг төслийг боловсруулж, сургуулиар орсон хүн бүх ашиглахад хялбар байхуйц универсаль дизайнтайгаар барьсан бөгөөд цаашид Монгол Улсын Засгийн газраас сургуулийн барилга барихад нь загвар болох юм.

